



ДОРНОД АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН
ГАЗАР

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025

НИЙГМИЙН УХААН Онлайн сорил-2

12 сарын 28 16.00-17.20

1.

Хүмүүсийн зохион байгуулалттай, чиг зорилготой харилцаа, тэдгээрийн үр дүнд бий болсон тогтвортой нэгдэл, өөрийгөө байнга нөхөн сэргээж байдаг бие даасан тогтолцооны нийлбэр нь.....юм. \ 1 оноо\

A. Нийгмийн бүтэц

B. Нийгмийн харилцаа

C. Нийгэм

D. Нийгмийн хандлага

E. Нийгмийн тогтолцоо

2.

Шинэ мэдлэг бүтээх, мэдлэгийг хойч үедээ дамжуулах, өсвөр үеийг нийгэмшүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх нь нийгмийн аль институтын үүрэг вэ? \ 1 оноо\

A. Гэр бүлийн

B. Боловсролын

C. Улс төрийн

D. Эдийн засгийн

E. Шашны

3.

Зөв тохируулна уу.

\ 3 оноо\

A	Нийгмийн хэм хэмжээ	1	Нийгмийн бүлгийн олонхын хүлээн зөвшөөрсөн хүлээлтэд нийцсэн төлөв
B	Нийгмийн гажуудал	2	Нийгэм нэгдэлтэй, тогтвортой оршин байхын тулд хүмүүсийн сахиж мөрдөх шаардлага
C	Аялдах үйлдэл	3	Нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй үл нийцэх төлөв

A. A2 B3 C1

B. A3 B2 C1

C. A3 B1 C2

D. A1 B3 C2

E. A2 B1 C3

4.

Нийгмийг амьд биетэй төстэй хэмээн үзэж, эд эрхтэн нь тухайн амьд биеийг амьдруулахын төлөө үүрэг гүйцэтгэж байдгийн адил нийгмийн институт нь нийгмийн болон бусад институтуудын оршин тогтнолын төлөө тодорхой үүрэг гүйцэтгэдэг гэсэн онол аль нь вэ?

\1 оноо\

- A. Нийгмийн онол
- C. Харилцан үйлдлийн онол
- E. Бүтэц чиг үүргийн онол

- B. Шалтгаант чанарын онол
- D. Зөрчилдөөний онол

5.

Тодорхой цаг хугацааны хүрээнд нийгмийн бүтэц, соёл, нийгмийн институт, хүмүүсийн зан үйл шинэчлэгдэхийггэдэг.

\1 оноо\

- A. Нийгмийн хувьсгал
- C. Нийгмийн хөдөлгөөн
- E. Нийгмийн хувьсал

- B. Нийгмийн өөрчлөлт
- D. Нийгмийн шилжилт

6.

Нийгмийн хэв маягуудыг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?

\1 оноо\

- A. Мал аж ахуйн нийгэм
- C. Газар тариалангийн нийгэм
- E. Аж үйлдвэржсэний дараах нийгэм

- B. Аж үйлдвэржсэн нийгэм
- D. Гар урлалын нийгэм

7.

Нийгмийн давхраажилтын хэмжигдэхүүнд аль нь хамаарахгүй вэ?

\1 оноо\

- A. Нэр хүнд
- C. Ёс суртахуун
- E. Эд баялаг

- B. Эрх мэдэл
- D. Боловсрол мэргэжил

8.

Тэгш бус байдлын хамгийн түгээмэл илрэл бол.....

\1 оноо\

A. Зиндаархал

B. Баялаг хуваарилалт

C. Статус

D. Давхраажилт

E. Хүсэл тэмүүлэл

9.

“Капитал”, “Коммунист намын тунхаг” бүтээлдээ капиталистууд болон ажилчин ангийн зөрчлийг авч үзээд энэ нь нийгмийн өөрчлөлтийн хөдөлгөгч хүч болдог гэж үзсэн сэтгэгч хэн бэ?

\2 оноо\

A. М. Вебер

B. К. Маркс

C. Э. Дюркгейм

D. Т. Парсонс

E. Ж. Г. Мид

10.

Боловсролын түвшнээс хамааралгүйгээр нийгмийн бүх хүмүүст хүртээмжтэй байдаг соёлын хэлбэрийг олж тэмдэглэнэ үү.

\1 оноо\

A. Ардын соёл

B. Элитийн соёл

C. Нийтийн соёл

D. Дагуул соёл

E. Гадны соёл

11.

“Монголын түүх, соёл бол үндэсний аюулгүй байдлын дархлаа мөн” гэж ямар хуульд заасан бэ?

\2 оноо\

A. Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуульд

B. Монгол улсын Үндсэн хуульд

C. Монгол улсын Соёлын тухай хуульд

D. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд

E. Монгол улсын Нийгмийн хамгааллын хуульд

12. Соёлыг илрэх байдлаар нь хэрхэн ангилдаг вэ?

\1 оноо\

- A. Соёлын хямрал түрэмгийлэл
- C. Эдийн болон оюуны соёл
- E. Соёлын нэгдэл, хуримтлал

- B. Эртний болон орчин үеийн соёл
- D. Соёлын даяаршил, зөрчил

13. Эдийн соёлд хамааралгүй нь аль вэ?

\1 оноо\

- A. Гар утас
- B. Хувцас
- D. Шинжлэх ухаан
- E. Барилга байгууламж

C. Телевиз

14. Оюуны өмчөөр хамгаалагдсан соёлын агуулга бүхий бараа бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэл, хуваарилалт, нийлүүлэлтийн тогтолцоог.....гэнэ.

\1 оноо\

- A. Соёлын дархлаа
- B. Соёлын үйлдвэрлэл
- C. Соёл судлал
- D. Соёлын бүтээгдэхүүн
- E. Соёлын менежмент

15. Үндэсний соёлын өвөрмөц өв санг дэлхий нийтэд үзүүлэн таниулах хэрэгцээ улам нэмэгдэж байгаа өнөө үеийн соёлын солилцооны гол хөтлөх хүч нь дотоодын болон олон улсынмөн.

\3 оноо\

- A. Соёлын аялал жуулчлал
- B. Соёлын үйлдвэрлэл
- C. Соёлын даяаршил
- D. Соёлын дархлаа
- E. Соёлын арга хэмжээ

16. Өнөө үеийн ардчилсан, нээлттэй гадаад харилцааны үндсэн дээр тусгаар соёлууд дэлхийн нэгдмэл соёлд нэгдэн нийлэх үйл явцыг юу гэж нэрлэдэг вэ?

\1 оноо\

- A. Дэд соёл
- B. Уламжлалт соёл
- C. Соёлын гадуурхал
- D. Соёлын даяаршил
- E. Хэлний соёл

17.

Соёлын эрх чөлөөний тулгуур ойлголтонд аль нь хамаарах вэ? \1 оноо\

- A. Бүх хүмүүс өөрийн хэл соёлоор бахархаж, сурч боловсрох, шашин шүтэх ба эс шүтэх эрх, соёлыг бүтээн туурвих бололцоог эдлэх нийгмийн баталгаагаар хангагдах
- B. Өөрийн тогтолцооны хүрээнд адилслыг буй болгох
- C. Өөрийн соёлын хүрээнд ялгааг буй болгох
- D. Амьдралын эгэл нөхцөл алдагдах
- E. Соёлын гадуурхал

18.

Соёлын эрх чөлөөний асуудалд хамааралгүй зүйл аль нь вэ? \1 оноо\

- A. Олон төрлийн нийгмийн баталгаагаар хангагдсан байх эрх
- B. Бүх хүмүүс эх хэлээрээ ярьж, өөрийн шашныг шүтэж, өөрийн бүтээн туурвих бололцоог эдлэх эрх
- C. Хүмүүс өөрсдийгөө илэрхийлэх, өөрийн хувийн чанараа хөгжүүлэх
- D. Баталгаат боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ
- E. Амьдралын хэв маягийг үгүйсгэх

19.

ДНБ –ийг өнөөгийн үнээр тооцсоныг юу гэж нэрлэдэг вэ? \1 оноо\

- A. Байнгын
- B. Бодит ДНБ
- C. Нэрлэсэн ДНБ
- D. Тогтмол
- E. Зах зээлийн

20.

ДНБ-ийг зардлаар тооцоход хамааралгүй зүйлийг олоорой \1 оноо\

- A. Гадаад хэрэглэгчийн зардал
- B. Өрх гэрийн хэрэглээний зардал
- C. Аж ахуйн нэгжийн зардал
- D. Төрийн зардал
- E. Хувь хүний хэрэглээний зардал

21.

Тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа, зохих хүүтэйгээр эргүүлэн төлөхөө амлаж байгааг баталсан үнэт цаасыг.....гэнэ \ 1 оноо\

A. Лиценз

B. Хувьцаа

C. Хадгаламж

D. Үнэт цаас

E. Бонд

22.

Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлогыг ямар бодлого гэдэг вэ? \1 оноо\

A. Төрийн сангийн буюу төсвийн бодлого

B. Төрийн мөнгө зээлийн бодлого

C. Эдийн засгийн бодлого

D. Засгийн газрын бодлого

E. Төрийн бодлого

23.

Улс орны эдийн засгийн хөгжлийн өсөлт, чадавхыг тодорхойлдог гол үзүүлэлт аль нь вэ? \2 оноо\

A. Үндэсний цэвэр бүтээгдэхүүн

B. Үндэсний нийт орлого

C. Нэг хүнд ноогдох ДНБ-ий өсөлт
ба бодит ДНБ-ий өсөлт

D. Валютын нөөц

E. Дотоодын нийт бүтээгдэхүүн

24.

Гүйлгээнээс мөнгө татах буюу мөнгөний нийлүүлэлтийг бууруулах бодлогыг ямар бодлого гэдэг вэ? \1 оноо\

A. Мөнгөний тэлэх

B. Мөнгөний хумих

C. Засгийн газрын

D. Сангийн яамны

E. Эдийн засгийн

25.

Нийт эрэлтийг нэмэгдүүлэхийн тулд төрөөс дараах арга хэмжээ авдаг. Ойлголтуудыг зөв харгалзуулна уу. \3 оноо\

A	Зээлийн хүүг бууруулах	1	Үнэт цаас гаргаж түүнийг эргүүлж худалдан авах замаар мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлөх
B	Гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээг өсгөх	2	Аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийж, энэ нь эцэстээ нийт эрэлт өсөхөд нөлөөлөх
C	Бонд гаргах	3	Аль болох бага хуримтлуулж илүү ихийг худалдан авснаар нийт эрэлтийг нэмэгдүүлэх

A. A3 B1 C2
D. A1 B3 C2

B. A3 B2 C1
E. A2 B1 C3

C. A2 B3 C1

26.

Экспорт, импортын зөрүүг.....гэнэ.

\1 оноо\

A. Гадаад худалдааны алдагдал
C. Гадаад худалдааны ашиг
E. Гадаадын хандив тусламж

B. Гадаадын хөрөнгө оруулалт
D. Гадаад худалдааны тэнцэл



27.

Улс орны эдийн засгийг санхүүжүүлэх гол үүргийг аль нь хүлээх вэ?

\1 оноо\

A. Сангийн яам
D. Арилжааны банк

B. Төв банк
E. Банк бус санхүүгийн байгууллага

C. Засгийн газар

28.

Ардчилсан нийгэм бүх иргэдэд адил тэгш боломж олгодог онцлогтой. Энэ нь хэн нэгнийг илүү харж, эрх дарх олгохгүй гэсэн үг юм. Энэ ардчиллын аль зарчим бэ? \2 оноо\

A. Хууль дээдлэх зарчим
C. Шударга байх зарчим
E. Зөвшилцлийн зарчим

B. Нээлттэй байх зарчим
D. Цөөнхийг хүндэтгэх зарчим

29.

Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэсэн засаглал хуваах онолыг үндэслэгчийг нэрлэнэ үү? \1 оноо\

A. Н. Макиавелли
C. М. Вебер
E. Ш. Монтескье

B. Ж. Локк
D. К. Маркс

30.

Чөлөөт нийгэм дэх иргэний нийгмийн гол үүрэг нь аль вэ?

\1 оноо\

A. Эрх чөлөөт байдлыг хангах
B. Төрийг хянаж, төрд хариуцлага хүлээлгэх
C. Хувь хүмүүс мөр мөрөө хөөх явдал
D. Ард түмэн төрд үг дуугүй үнэнч байх
E. Сонгуульд идэвхтэй оролцох

31.

..... нь төрөөс үл хамаарах өөр хоорондын харилцаа, эрх зүйгээр зохицуулагддаг хувь хүмүүс, анги, бүлэг, институтуудын нийлбэр цогц юм. \1 оноо\

A. Нийгэм
C. Аж үйлдвэржсэн нийгэм
E. Эртний нийгэм

B. Социалист нийгэм
D. Иргэний нийгэм

32.

Иргэн хүн сонгуульд оролцох нь нийгмийн аль хүрээний харилцаанд хамаарагдах вэ?

\1 оноо\

A. Социал хүрээ
C. Эдийн засгийн хүрээ
E. Оюун санааны хүрээ

B. Улс төрийн хүрээ
D. Хүмүүнлэгийн хүрээ

33.

Сонгуульд өрсөлдөгчөөсөө илүү санал авсан нь ялалт байгуулдаг. Дотроо энгийн олонх, үнэмлэхүй олонх, харьцангуй олонх гэсэн аргатай сонгуулийн тогтолцоо аль нь вэ?

\1 оноо\

A. Холимог
D. Уламжлалт

B. Пропорциональ
E. Чөлөөт сонгууль

C. Мажоритар

34.

Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл нь ард түмэнд үнэн зөв мэдээлэл хүргэхэд дараах зарчмуудыг мөрдөнө. Хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ?

\1 оноо\

- A. Ард түмний дуу хоолой болох
- B. Нэг хүний эрх ашгийн төлөө бус олон түмний тусын тулд үнэн зөв мэдээлэл дамжуулах
- C. Нас хүйс, шашин шүтлэг, боловсролын түвшинг харгалзахгүйгээр бүх нийтэд тэгш хүргэх боломжийг нь хуулиар хангах
- D. Намын ажлаа тайлагнах
- E. Хэвлэл мэдээллийн ажилтнууд болон сэтгүүлчдийн эрх чөлөөг хамгаалах

35.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийгэмд гүйцэтгэх чиг үүргийг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?


\3 оноо\

- A. Цэнгэн баясгах, боловсрол олгох
- B. Мэдээллээр хангах
- C. Иргэдэд өөрийн гэсэн санаа бодлыг төлөвшүүлэхэд оролцон туслах
- D. Хяналт шалгалт, шүүмжлэл өрнүүлэх
- E. Улс төрийн шийдвэр гаргахад оролцох

36.

Д. Истоны улс төрийн системийн загварыг гүйцээгнэ үү.

\1 оноо\



- А. А. шийдвэр, Б. эргэх холбоо, В. үр дүн, Г. хувиргалт
 В. А. хувиргалт, Б. эргэх холбоо, В. шийдвэр, Г. үйлдэл
 С. А. эргэх холбоо, Б. хувиргалт, В. зөвшилцөл, Г. үр дүн
 Д. А. хэлэлцээр, Б. хувиргалт, В. үр дүн, Г. шийдвэр
 Е. А. үйлдэл, Б. хувиргалт, В. эргэх холбоо, Г. шийдвэр

37.

.....гэдэг нь хүн бүр хүмүүн болохынхоо хувьд адил үнэ цэнэтэй бөгөөд тодорхой үндсэн эрх, эрх чөлөөг эдлэх тухай ойлголт юм.

\1 оноо\

- А. Хүний эрхэм чанар
 В. Хүний эрх
 С. Хүний нэр төр
 Д. Хүний үнэлэмж
 Е. Хүний мөс чанар

38.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал хэдэн онд батлагдсан бэ?

\1 оноо\

- А. 1957
 В. 1954
 С. 1946
 Д. 1948
 Е. 1990

39.

Нийгмийн хамгааллын эрх зүйн харилцаа ньбагэсэн хоёр төрөлтэй.
\1 оноо\

- A. Нийгмийн даатгал, нийгмийн хамгаалал
- C. Нийгмийн халамж, нийгмийн тусламж
- E. Нийгмийн хамгаалал, нийгмийн даатгал

- B. Нийгмийн даатгал, нийгмийн халамж
- D. Нийгмийн халамж, нийгмийн хамгаалал

40.

Ажилгүйдлийн тэтгэмжийг ямар нөхцөлд олгодог вэ? \2 оноо\

- A. Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 5 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
- B. Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 18 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
- C. Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
- D. Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
- E. Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд

41.

..... бол засаглалын эрх мэдлийг хуваарилах, хүний эрхийг баталгаажуулах, улс орны суурь гол харилцааг зохицуулах үүрэгтэй хамгийн дээд хүчин чадалтай засаг төрийн гол хууль юм.
\2 оноо\

- A. Үндсэн хууль
- D. Хөдөлмөрийн хууль

- B. Төрийн хууль
- E. Боловсролын хууль

- C. Монгол улсын хууль

42.

Иргэн А нь малаа бэлчээрт гаргахын тулд Б-тэй зөвшилцөн түүний газрыг хязгаартай ашиглах гэрээ байгуулж хоёр тал тохиролцсон. Хэсэг хугацааны дараа гэрээнд тусгагдсан зүйлүүд зөрчигдөж, иргэн Б ашиг орлогоо алдаж, өмч хөрөнгөнд нь хохирол учирчээ. Энэ тохиолдолд иргэн Б ямар шатны шүүхэд нэхэмжлэл гаргах вэ? \1 оноо\

A. Аймаг нийслэлийн шүүх

B. Иргэний хэргийн дунд шатны шүүх

C. Захиргааны хэргийн анхан шатны шүүх

D. Захиргааны хэргийн дунд шатны шүүх

E. Иргэний хэргийн анхан шатны шүүх

43.

Эрх зүйн зөрчлийг гэмт хэргийн ба гэмт хэргийн бус гэж ангилдаг. Хуульд заасан гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдлийг эрх зүйн зөрчил гэж хэлдэг. Тэгвэл эс үйлдэл гэж юу вэ? \1 оноо\

A. Хуульд заасан үүргийг гүйцэтгэхгүй байхыг

B. Хуульд заасан үүргээ сайн биелүүлэхийг

C. Ямар ч үйлдэл хийгээгүй байхыг

D. Мэдээгүй байхыг

E. Дэг журамгүй байхыг

44.

Гэм хорын тухай ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

\3 оноо\

A	Гэм хор	1	Хохирлын улмаас үүссэн үр дагавар
B	Хохирол	2	Эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус гэж ангилна.
C	Хор уршиг	3	Эрх зүйн зөрчлийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, аюулгүй байдалд учирсан үр дагавар.

A. A2 B1 C3

B. A3 B2 C1

C. A2 B3 C1

D. A1 B3 C2

E. A1 B2 C3

45.

Иргэн хуулийн этгээдээс захиргааны байгууллагад гомдол гаргах хугацааг хоногийн дотор байхаар тогтоож өгсөн байдаг. \1 оноо\

A. 15

B. 30

C. 14

D. 45

E. 10

46.

Аль нь захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах вэ? \3 оноо\

A. Зохиогчийн эрхийг зөрчиж байгаа бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, худалдсан, түгээсэн, улсын хилээр нэвтрүүлсний улмаас зохиогчид их хэмжээний хохирол учирсан бол

B. Иргэн Э нь өөрийн эзэмшлийн PRIUS 30 маркийн автомашиныг түрээсийн гэрээгээр Б-д шилжүүлэв. Гэтэл 1 сарын дараа Б нь автомашиныг осолд оруулж дахиж унах аргагүй болгожээ. Тэрээр өөрийн өмч хөрөнгөнд халдсан гэж үзээд

C. Иргэн Ц нь өөрийг нь ямар ч үндэслэлгүйгээр төрийн албанаас халсан гэж үзээд

D. Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар өөрийн мэдэлд шилжүүлэн авсан нь тогтоогдвол

E. Төр нь хүний тодорхой эрхийг хүлээн зөвшөөрөөгүй бол

47.

Олон улсын харилцаанд оролцох үйл ажиллагааны чиглэлүүдэд хамааралгүйг олно уу.

\1 оноо\

A. Эдийн засаг, худалдаа

B. Байгаль орчин

C. Улс төр, эрх зүй

D. Шинжлэх ухаан

E. Хүмүүнлэгийн

48.

НҮБ-ийн үндсэн зорилтуудыг нэрлэхдээ илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? \1 оноо\

A. Гадаад худалдааг хөгжүүлж, ашиг олох

B. Дэлхий дахинд энх тайван, аюулгүй байдлыг сахин хангах

C. Үндэстэн улс орнуудын хооронд найрсаг харилцааг хөгжүүлэх

D. Хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэх

E. Бичиг үсэг үл мэдэх, өвчин эмгэг, өлсгөлөн ядуурлыг даван туулахад туслах

49.

Гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дүүрэн дайчлан зохион байгуулах шаардлага манай гадаад бодлогын ямар зарчим бэ? \1 оноо\

A. Олон тулгуурт байх

B. Тэнцвэртэй байх

C. Үндэсний эрх ашигт нийцсэн байх

D. Идэвхтэй байх

E. Эрх тэгш байх

50.

Боловсрол, шинжлэх ухаан, соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилго бүхий НҮБ-ын төрөлжсөн байгууллагыг нэрлэнэ үү. \1 оноо\

A. ЮНЕСКО

B. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

C. ЮНИСЕФ

D. Хөгжлийн хөтөлбөр

E. ЮНИДО

51.

Олон улсын харилцааны улс бус оролцогчид хамаарахгүй ойлголтыг олно уу. \2 оноо\

A. Буддын шашны төвүүд

B. Coca Cola компани

C. Тусгаар тогтносон улсууд

D. Эмнэсти интернэйшнл

E. Далай лам

52.

Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд гадаад бодлогыг ямар төрлүүдэд ангилсан бэ? \2 оноо\

A. Улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, соёл, хүмүүнлэгийн

B. Улс төр, эдийн засаг, боловсрол соёл, хүмүүнлэгийн

C. Хоёр талын ба олон талт хамтын ажиллагааны

D. Бүс нутгийн ба тив дамнасан

E. Бүс нутгийн, олон улсын, тив дамнасан

53.

Монгол улсын Зүүн хойд Азийн \ЗХА\ улс орнуудтай харилцан ойлголцож хамтран ажиллах онцлог нөхцлүүдэд аль нь тохирохгүй вэ? \1 оноо\

- A. Монгол улсын олон улсын нэр хүнд, байр суурийг бэхжүүлэхэд ЗХА-ийн улсуудын дэмжлэг нөлөө их ач холбогдолтой.
- B. Монголын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын ихэнх хувийг ЗХА орнууд эзэлдэг
- C. Ихэнх орнууд нь өндөр хөгжилтэй, бие биетэйгээ хиллэн оршдог, өөрийн үл давтагдах онцлогтой бүс нутаг
- D. Гадаад харилцааны бодлогын хаалттай зарчим, үйл ажиллагаа
- E. Эдгээр улстай харилцан ойлголцож, хамтран ажиллаж туршлагаас нь суралцаж улс орноо хөгжүүлэх бодлого МУ-ын гадаад харилцааны нээлттэй байх зарчимд нийцнэ.

54.

54. Монгол улс гуравдагч хөрштэйгээ хэзээнээс дипломат харилцаа тогтоож ирснийг зөв холбоно уу \3 оноо\

A	Монгол улс ба АНУ-ын харилцаа	1	1990 онд
B	Монгол улс ба Япон улсын харилцаа	2	1987 онд
C	Монгол улс ба БНСУ-ын харилцаа	3	1972 онд

A. A2 B1 C3 B. A3 B2 C1 C. A3 B1 C2 D. A1 B3 C2 E. A2 B3 C1

55.

Монгол улс “Мянганы сорилт”-ын сан хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж ирсэн. Энэ нь аль улсын тусламж дэмжлэг вэ? \1 оноо\

A. Япон B. АНУ C. ОХУ D. Турк E. БНХАУ

56.

Зөөлөн хүчний төрлүүдийг дурьдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? \3 оноо\

A. Дипломат гадаад бодлого B. Соёл, боловсрол C. Бизнес инноваци
D. Цэргийн E. Улс төрийн үнэт зүйл, институтын хөгжил

2.1.

2.1 Нийгмийн өөрчлөлтүүдийг зөв харгалзуулна уу?

\5 оноо\

a	Нийгмийн дэвшил	1	Нийгэм түүхийн хурдац нь буурах хандлага бүхий сөрөг үр дагавартай хөдөлгөөн
b	Нийгмийн шинэчлэл	2	Нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан тодорхой цаг хугацаан дахь иж бүрэн суурь өөрчлөлт
c	Нийгмийн ухралт	3	Нийгэм болон хүний амьдралын нөхцөл, чанар дээшлэх, амьдрах ухаан төгөлдөрших зэрэг эерэг үр ашгийн цогц
d	Нийгмийн хөдөлгөөн	4	Нийгмийн бодит байдлын дэс дараатай өөрчлөлт хөдөлгөөн
e	Нийгмийн үйл явц	5	Нийгэмд болон нийгмийн бүлгүүдэд гарч буй өөрчлөлтийг дэмжих, эсвэл эсэргүүцэх зорилготой хамтын үйлдлүүдийн цогц.

2.2.

2.2 Соёлын даяршлын талаарх ойлголтуудыг зөв харгалзуулна уу?

\5 оноо\

a	Соёлын даяаршил	1	Ард түмэн өөрийн соёлын хэм хэмжээ, зан үйл, хэл, үнэлэмжийн баримжааллыг ухаарч ойлгох, тэрхүү байр сууринаас өөрийгөө ойлгох, соёлыг тээгч гэдгээ ухаарах байдал.
b	Соёлын орон зай	2	Эх хэлээрээ ярьж, өөрийн шашныг шүтэж, өөртөө хэрэгтэй зүйлээ бүтээж туурвих бололцоог эдлэх
c	Соёлын адилсал	3	Соёлын үнэлэмжүүдийн харилцан нөлөөллөөр бий болж байдаг орчин ба улс үндэстэн, хүмүүсийн хамтын мэдрэмж
d	Соёлын дархлаа	4	Улс орнуудын хоорондын харилцаа солилцоо эрчимжиж хэл, соёл, техник технологийн нэгдэн нягтрах үйл явц эрчимтэй явагдаж уламжлалт амьдралын хэв маяг сэтгэлгээнд өөрчлөлт гарах үзэгдэл
e	Соёлын эрх чөлөө	5	Өөрийн үнэт зүйлсээ хамгаалж, оршин тогтнолоо бэхжүүлэн баталгаажуулах чадвар

2.3.

2.3 Макро эдийн засгийн асуудлуудыг зөв харгалзуулна уу?

\5 оноо\

a	Ажилгүйдэл	1	Иргэдийн худалдан авах чадвар муудаж олон үйлдвэрийн газрууд хаалгаа барьснаас Дорж ажилгүй болсон.
b	Мөчлөгийн	2	Уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт буурсантай холбоотой томоохон уурхай хаагдаж олон уурхайчид ажилгүй болсон.
c	Шилжилтийн	3	Ажиллах хүчний эрэлтээс нийлүүлэлт давсан үзэгдэл.
d	Бүтцийн	4	Баасан замын компанид ажилладаг ч өвлийн улиралд ажил нь түр хугацаагаар зогссон тул одоо ажилгүй байгаа.
e	Улирлын	5	Батын эхнэр аймгийн төвд ажиллахаар томилогдсон тул Бат аймгийн төвд ирээд хэсэг хугацаанд ажилгүй болсон.

2.4.

2.4 А. Алмондын сонирхлын бүлгийн хэв шинжийг зөв харгалзуулна уу?

\5 оноо\

a	Сонирхлын бүлэг	1	Тодорхой зохион байгуулалтгүй хэсэг бөөн хүмүүсийн цугларалт, бослого, үймээн.
b	Аномик	2	Зохион байгуулалтгүй боловч аномик бүлгээс ялгаатай нь хүмүүс голдуу яс үндэс, угсаа гарал, арьс өнгө, шашин шүтлэг, нас хүйс зэргээрээ хамрагддаг.
c	Эвсэл холбооны	3	Хувийн эрх ашгийн төлөө бус, нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх зорилгоор сайн дураараа үүсгэн байгуулсан байгууллага, хөдөлгөөн
d	Эвсэл холбооны бус	4	Цэрэг зэвсэглэл, арми, сүм хийд зэрэг субъектын шууд удирдлаган дор зохион байгуулалттай үүсгэн байгуулагддаг.
e	Байгууллагдажсан	5	Өөрийн гэсэн тодорхой зорилго, чиглэлд үндэслэгдсэн зохион байгуулалттай бүлэг.

№	A	Оноо
1	C	1
2	B	1
3	A	3
4	E	1
5	B	1
6	D	1
7	C	1
8	D	1
9	B	2
10	C	1
11	D	2
12	C	1
13	D	1
14	B	1
15	A	3
16	D	1
17	A	1
18	E	1
19	C	1
20	E	1
21	E	1
22	A	1
23	C	2
24	B	1
25	C	3
26	D	1
27	B	1
28	C	2

№	A	Оноо
29	E	1
30	B	1
31	D	1
32	B	1
33	C	1
34	D	1
35	E	3
36	B	1
37	A	1
38	D	1
39	B	1
40	C	2
41	A	2
42	E	1
43	A	1
44	C	3
45	B	1
46	C	3
47	B	1
48	A	1
49	D	1
50	A	1
51	C	2
52	A	2
53	D	1
54	E	3
55	B	1
56	D	3

	Хоёрдугаар хэсэг А					
№	A	B	C	D	E	Оноо
2.1	3	2	1	5	4	5 оноо
2.2	4	3	1	5	2	5 оноо
2.3	3	1	5	2	4	5 оноо
2.4	3	1	5	2	4	5 оноо